



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.НАРАНБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 51 71, Цахим шуудан: contact@met.gov.mn.
Цахим хуудас: www.mess.gov.mn

2025. 02. 18 № 11/855
таний -ны № -т

Г Тушаалын хэрэгжилтийн талаар хариу
хүргүүлэх тухай



Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газраас 2023 онд Техникийн ашигласан тос, хаягдал аккумуляторын цуглуулах, хадгалалт, тээвэрлэлт, устгалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад авто засвар-215, автомашины хаягдал цэнэг хураагуур (хаягдал аккумулятор) тээвэрлэх, цуглуулах, түр хадгалах, дахин боловсруулах үйлдвэр-8, хосолмол хөдөлгүүртэй автомашины батарей (NIMH) экспортлох үйл ажиллагаа эрхлэгч-1, хаягдал тос цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэр-4, хоёрдогч түүхий эд авах цэг-25, бусад-23 нийт 293 объектын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтад хамрагдсан авто засварын газрын 40 хувь нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, 62 хувь нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй зөрчил дутагдлыг илрүүлж 90 аж ахуйн нэгж, иргэнд 362 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж 4 хүн, хуулийн этгээдэд 1030.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчлийн үр дагаврыг арилгуулсан байна.

2024 онд Аюултай хог хаягдал үүсгэгч 104, аюултай хог хаягдал дахин боловсруулах 7 нийт 111 объектыг хяналт шалгалтад хамруулахад 45 хувь нь аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулж шилжүүлдэг, бусад нь эх үүсвэр дээрээ хадгалж байна. Шалгалтад хамрагдсан объектуудын үйл ажиллагаанаас гарсан хуванцар сав 22 тн, химийн бодисын сав 5801 ширхэг, шуудай 103.4 тн, хийн баллон 213 ширхэг, ашиглалтын хугацаа дуссан химийн бодис 2.44 тн, ашигласан тос, масло 1700 литр, 203 тн, төмөр сав 6.2тн, тостой арчих материал 2.4 тн нийт 339.4 тн, 6014 ширхэг, 1700 литр аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэн устгуулан байгаль орчинд сөрөг нөлөөлөх үзүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлсэн. Хяналт шалгалтад нийт 286 объектыг хамруулж, 128000.0 мянган төгрөгийг торгох шийтгэл, 1043000.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг оногдуулж, эрсдэлийн түвшин дунджаар 39 хувьтай, хуулийн хэрэгжилт 60 хувьтай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаартай жагсаалт батлах тухай хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангуулахаар Улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/06 дугаартай "Энгийн болон аюултай хог хаягдал хадгалах, ашиглах, дахин боловсруулах устгах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн нутагт дэвсгэрт байрлах иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын үйлдвэрлэсэн болон импортолсон бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагаанд хяналт шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

САЛБАРЫН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.МОНХТОГОХ

Боловсруулсан:	Ч.Дамдинжан
(гэрчилж) (герчилжийн зөвлөл)	
Жинчссэн:	М.И.Ц.Симонов
(түүхий усны) (герчилжийн зөвлөл)	
Хувь:	2